



**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
МАТЕРИАЛ**

**Тавантолгой**

**2025 он**

## ХУРЛЫН ЗАР

**Компанийн нэр:** “Тавантолгой” ХК

**Хурал хуралдах газар:** Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-овоо 3-р баг, “Тавантолгой” ХК-ийн байр, Хурлын танхим

**Хурал хуралдах өдөр, цаг:** 2025 оны 04 сарын 28-ны өдөр 11:00 цагт болно.

**Хурал зохион байгуулах хэлбэр:** Танхим

**Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр:**

2025 оны 04 сарын 07-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Тавантолгой ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах
2. Тавантолгой ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Тавантолгой ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайланг танилцуулах
4. Тавантолгой ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг танилцуулах
5. Төлөөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг батлах тухай

Хувьцаа эзэмшигчид 2025 оны 04 сарын 25-ны өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд дараах сувгуудаар болон компанийн өөрийн цахим хуудсаар дамжуулан хурлын материалтай танилцах боломжтой.

- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани
- “Тавантолгой” ХК-ийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө-36, “Монгол Савхи” ХК-ийн байр, 602 тоот
- “Тавантолгой” ХК-ийн оффис, Хаяг: Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-овоо 3-р баг, Бор 2-р гудамж, 207 тоотод байрлах байранд ирж хурал зохион байгуулах комиссын гишүүдэд мэдэгдэн хурлын баримт бичигтэй танилцах боломжтой.

Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийг санал өгөх боломжоор хангах зорилгоор 2025 оны 04 сарын 25-ны өдрийн 16:00 цаг хүртэл доорх сувгуудаар дамжуулан урьдчилсан саналын хуудсыг хүлээн авна. Үүнд:

- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани
- “Тавантолгой” ХК-ийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө-36, “Монгол Савхи” ХК-ийн байр, 602 тоот
- “Тавантолгой” ХК-ийн оффис, Хаяг: Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-овоо 3-р баг, Бор 2-р гудамж, 207 тоот

Холбоо барих: 99010179, 88084783

И-мэйл хаяг: info@tavantolgoi.mn

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Зохион байгуулах комиссын дарга:  
Зохион байгуулах комиссын гишүүд:

Ш.Отгонбаяр /ТУЗ-ийн дарга/  
Ч.Гүнждагва /Гүйцэтгэх захирал/  
С.Идэрсүрэн /Захиргаа удирдлагын  
газрын захирал/  
Б.Нарантуяа /Санхүү эдийн засаг,  
төлөвлөлтийн газрын захирал/  
Э.Болд-Эрдэнэ /Уул уурхай  
технологийн газрын захирал/  
Н.Адьяацэрэн /ТУЗ-ийн нарийн  
бичгийн дарга/

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



ТАВАНТОЛГОЙ ХК

ӨМНӨГОВЬ АЙМАГ

## “ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 15

Цогтцэций сум

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 59.10 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 65.4, 65.5, 65.6 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.5, 6.6 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00 цагт Өмнөговь аймгийн Цогтцэций сум, “Тавантолгой” ХК-ийн оффисын хурлын танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар, хурлаар хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, хурлын дэгийг 2 дугаар хавсралтаар, хуралтай холбоотой танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг 3 дугаар хавсралтаар, хурлын саналын хуудасны загварыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох баримт бичгүүдийн хамт 2025 оны 03 дугаар сарын 18-ны дотор Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлсүгэй.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Санхүүгийн зохицуулах хорооны баталсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу олон нийтэд зарласугай.
6. Тус тогтоолын хавсралтаар баталсан Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичгийн жагсаалтыг бэлэн болгож 3 дугаар сарын 26-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
7. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 20-р

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

хороо, Чингисийн өргөн чөлөө-36, “Монгол Савхи” ХК-ийн байр, 602 тоот хаягт байрлах компанийн Улаанбаатар хот дах төлөөлөгчийн газар, Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Цагаан-овоо 3-р баг, Бор 2-р гудамж 207 тоот “Тавантолгой” ХК-ийн байр хаягт байрлах компанийн оффис болон хувьцаа эзэмшигчийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниар дамжуулан урьдчилсан саналын хуудсыг хүлээн авах ба саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2025 оны 04 сарын 25-ны өдрийн 16:00 цаг байна.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Шаравын Отгонбаярыг сонгосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ийн дарга Ш.Отгонбаяр, гишүүдээр Гүйцэтгэх захирал Ч.Гүнждагва, Захиргаа удирдлагын газрын захирал С.Идэрсүрэн, Санхүү эдийн засаг, төлөвлөлтийн газрын захирал Б.Нарантуяа, Уул уурхай технологийн газрын захирал Э.Болд-Эрдэнэ, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Адьяацэрэн нарыг томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар зөвлөх үйлчилгээ үзүүлэгч “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Хөрөнгө оруулалтын албаны захирал С.Дөлгөөн, гишүүдээр Хууль эрх зүйн албаны дарга М.Цолмон, Дотоод хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Дархантөгс нарыг тус тус томилсугай.
11. Хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг “Компанийн тухай” хууль болон “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуульд заасан хугацаанд Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэхийг Хурал зохион байгуулах комиссын дарга (Ш.Отгонбаяр)-д даалгасугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит Хурал зохион байгуулах комиссын баталсан төсвийн хүрээнд холбогдох зардлыг үйл ажиллагааны зардлаас зарцуулахыг гүйцэтгэх захирал (Ч.Гүнждагва)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Ш.ОТГОНБАЯР

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: С.Дөлгөөн /Зөвлөх үйлчилгээ үзүүлэгч “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн Хөрөнгө оруулалтын албаны захирал/  
Комиссын гишүүд: М.Цолмон /Хууль эрх зүйн албаны дарга/  
С.Дарханбаатар /Дотоод хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн/

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДЭГ

	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах этгээд
1	Хурлын ирцийг бүртгэх	10:00-11:00	Тооллогын комисс
2	Хурлын ирцийг хурлын дарга болон хуралд оролцогч нарт мэдээлэх	11:00-11:10	Тооллогын комисс
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	11:10-11:20	Хурлын дарга
4	<b>Хурлаар хэлэлцэх асуудлууд</b>		
	1. Тавантолгой ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай	11:20-11:40	Гүйцэтгэх захирал Ч.Гүнждагва
	2. Тавантолгой ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах	11:40-11:50	Хурлын дарга Ш.Отгонбаяр
	3. Тавантолгой ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайланг танилцуулах	11:50-12:00	Хурлын дарга Ш.Отгонбаяр
	4. Тавантолгой ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг танилцуулах	12:00-12:05	Хурлын дарга Ш.Отгонбаяр
	5. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах	12:05-12:20	Хурлын дарга Ш.Отгонбаяр
	6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр сонгох тухай	12:20-12:30	Хурлын дарга Ш.Отгонбаяр
	7. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг батлах тухай	12:30-12:40	Гүйцэтгэх захирал Ч.Гүнждагва
5	Хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт, хариулт	12:40-12:55	Хурлын дарга
6	Саналын хуудас бөглөх заавар танилцуулах	12:55-13:05	Тооллогын комисс
7	Саналын хуудсаар санал авах	13:05-13:15	Тооллогын комисс

	Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналыг тоолж, нэгтгэх, боловсруулах	13:15-13:30	Тооллогын комисс
8	Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах	13:30-13:40	Тооллогын комисс
9	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	13:40-13:50	Хурлын дарга
10	Хурлыг хаах	13:50-14:00	Хурлын дарга

Хурлын үргэлжлэх нийт хугацаа: 3 цаг 00 мин

Шаардлагатай тохиолдолд хугацааг сунгаж болно.

### **ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

# КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт

2024 оны жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа	2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	"Тавантолгой" ХК Регистрийн дугаар: 2016656 Улсын бүртгэлийн дугаар: 1110001005 Үнэт цаасны код: TTL Утас: 7535-5555, 9500-1619
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Уул уурхай, Нүүрс олборлолт
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар Тайлан гаргасан огноо: 2024.03.22
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	52,665,200 ширхэг
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Хянасан: Гүйцэтгэх захирал Ч.Гүнждагва
1	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/
Санхүүгийн байдлын үзүүлэлт	2024 онд нийт хөрөнгийн дүн 783,424.46 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 91.3 хувь буюу 715,091.45 сая төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 8.7 хувь буюу 68,333,0 сая төгрөгийг эзэлж байна. Нийт эх үүсвэр 783,424.46 сая төгрөг , үүнээс өр төлбөр 274,097.63 сая төгрөг, хуримтлагдсан ашиг 503,356.1 сая төгрөг байна. 2024 оны санхүүгийн тайлан хавсаргав.
Орлогын тайлан	2024 онд 1,158,398.0 сая төгрөгийн орлоготой, 589,030.42 сая төгрөгийн зардалтай, 549,159.58 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.



	Өмчийн өөрчлөлтийн тайлан	2024 онд 549,159.58 сая төгрөгийн ашигтай ажиллаж оны эцэст эздийн өмчийн дүн 509,326.83 сая төгрөг болсон байна.
	Мөнгөн гүйлгээний тайлан	2024 онд бүх цэвэр мөнгөн гүйлгээ 344,727.54 сая төгрөг, оны эцсийн мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 373,701.07 сая төгрөг байна.
1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	2024 оны санхүүгийн тайланд Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газар хөндлөнгийн Аудитаар ажиллаж "Тавантолгой" ХК-ийн санхүүгийн тайлан тэнцэлд үнэлгээ хийгдэж байна.	
1.2	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/	
	Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газар 2024 оны санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийсэн бөгөөд аудитын дүгнэлт, тайланг дууссан даруйд хавсаргах болно.	
2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Тус компани тайлант онд нийт 1,158,398.00 сая төгрөгийн орлоготой, 609,238.42 сая төгрөгийн зардалтай, 412,355.27 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.
2.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа: ..... Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа: ....
2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Компанийн үндсэн үйлдвэрлэлийн тоо хэмжээг нэмэгдүүлэх, нүүрсний гадаад зах зээлийн таатай нөхцөл байдлыг ашиглах, цар тахлын нөлөөнөөс гарч, борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажилласан. Нүүрс борлуулалтыг Засгийн газрын 2022 оны 466 дугаар тогтоолоор батлагдсан "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам" болон зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан борлуулалт хийж ажилласан. 2024 онд улсын хэмжээнд нийт 83.7 сая.тн нүүрс

		<p>экспорт хийсэн бөгөөд компанийн хувьд 2.3 сая тонн буюу 2.7 хувийг эзэлж байна. Түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалж хөрс хуулалтын зардал өссөн, бараа бүтээгдэхүүний хомсдолоос шалтгаалж хөрс хуулалтын ажилд зогсолт саатал гарч, хөрс хуулалт төлөвлөсөн хэмжээнээс бага гарсан.</p> <p>Нүүрсний үнийг гадаад зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан оновчтой зохион байгуулж ажилласан. Гадаад валютын ханшийн өсөлт нь борлуулалтын орлогод шууд нөлөөлсөн.</p>
2.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	“Тавантолгой” ХК нь 2024 онд Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй, НБББодлого нь компанийн НББББичгийн дагуу бүртгэсэн.
2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	“Тавантолгой” ХК нь эргэлтийн хөрөнгөөр санхүүжиж ямар нэгэн зээл аваагүй ажилласан.
3	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
		Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй.
4	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
		<p>➤ “Тавантолгой” ХК нь компанийн засаглалын бүтцийн хувьд дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хувьцаа эзэмшигчдийн хурал,</li> <li>- Төлөөлөн удирдах зөвлөл, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга,</li> <li>- Гүйцэтгэх захирал,</li> <li>- Газрын захирал,</li> <li>- Хэлтсийн захирал,</li> <li>- Албаны дарга,</li> </ul> <p>➤ Тайлант хугацаанд компанийн удирдлагын хүрээнд дараах үйл ажиллагаа явагдсан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• <u>Хувьцаа эзэмшигчдийн хурал</u>: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14 цагаас компанийн төв байранд 95.2 хувийн ирцтэйгээр зохион байгуулсан. Хуралтай холбоотой мэдээллийг холбогдох</li> </ul>

	<p>журмын дагуу олон нийтэд мэдээлэх, холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлэн ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> <li>• <u>Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал</u>: 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 11 цагаас компанийн төв байранд 95 хувийн ирцтэйгээр ээлжит бус хурлыг хуралдуулан хэлэлцэхээ товлосон асуудлуудыг хэлэлцэн зохион байгуулсан. Хуралтай холбоотой мэдээллийг холбогдох журмын дагуу олон нийтэд мэдээлэх, Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэн ажилласан.</li> <li>• <u>ТУЗ-ийн гишүүд</u>: Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 9 гишүүн (хараат бус 3 гишүүн, ердийн 6 гишүүн) сонгон ажилласан.</li> <li>• <u>ТУЗ-ийн дэргэдэх хороод</u>: Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороог байгуулан ажиллаж байна.</li> <li>• <u>ТУЗ-ийн хурал</u>: Үйл ажиллагааны журамд заасны дагуу хурлын үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд 25 удаагийн танхимын болон танхим, цахим хосолсон хурал, 11 удаагийн эчнээ санал хураалтаар нийт 85 тогтоол гарган ажилласан.</li> </ul>
5	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл
	Нүүрс борлуулалтын хувьд 2024 онд гадаад зах зээлийн таатай нөхцөл байдалтай уялдаатайгаар жилийн эхний хагаст өндөр дүнтэй биржийн арилжаа явагдаж борлуулалт хийгдсэн. Зах зээлийн хувьд 100% БНХАУ-ийн зах зээлээс хамааралтай байгаа бөгөөд нүүрс тээвэрлэлт, хилийн нөхцөл байдал сүүлийн хагаст тогтворгүй хувьсамтгай байсан. Мөн салбарын бодлого шийдвэр тодорхойгүй, эрсдэлтэй байна гэж үзэж байна. 4-р улирлын хувьд гадаад зах зээлийн нөхцөл байдлаас хамаарч борлуулалтын эрс буурч биржийн арилжаа зарласан боловч оролцогчгүйгээс болж амжилтгүй болж байсан.
6	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	2024 оны 12 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар 5 болон түүнээс дээш хувь эзэмшигч байсан хувьцаа эзэмшигчид: <ol style="list-style-type: none"> <li>1. Орон нутгийн өмч – 51%</li> <li>2. Ажнай корпораци ХХК – 19.78%</li> <li>3. Шандас Импекс ХХК – 16.31%</li> </ol>
7	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл
	Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэх зорилгоор хувьцаа нэмж гаргаагүй.
8	Ногдол ашгийн мэдээлэл
	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн хурлын 03 дугаартай тогтоолоор 2023 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд нэгж хувьцаанд 4996 төгрөг олгох шийдвэрийг гаргасан. Шийдвэрийн дагуу ногдол ашгийг компани болон

	Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 100% хуваарилж ажилласан.
9	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл:
	2024 онд нийт 42.8 сая метр куб уулын цулын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд үүнээс 37.5 сая метр куб хөрс, 7.5 сая тонн нүүрс. Гүйцэтгэлээр нийт 24 сая метр куб хөрс хуулалтын ажил гүйцэтгэн 4.3 сая тонн нүүрс олборлон 2.7 сая тонн нүүрсийг гадаад, дотоодын зах зээлд борлуулсан. Нийт борлуулалт 1,158,398,002.6 мян.төг. Борлуулалтын өртөг 589,030,425.6 мян.төг, татварын дараах цэвэр ашиг 412,355,270.3 мян.төг
10	
Мэдээлэл гаргач этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Ч.Гүнждагва  Албан тушаал: "Тавантолгой" ХК-ийн Гүйцэтгэх захирал  Гарын үсэг: ..... (Тамга/тэмдэг)	
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Ч.Төрмандах Албан тушаал: "Тавантолгой" ХК-ийн Төлөвлөлтийн эдийн засагч Гарын үсэг: .....	
Овог, нэр: Н.Адьяацэрэн Албан тушаал: "Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Гарын үсэг: .....	

# НОГДОЛ АШГИЙН ТАЛААР



ТАВАНТОЛГОЙ ХК  
ӨМНӨГОВЬ АЙМАГ  
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 11

Цогтцэций сум

## Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.8 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн Долоогийн 7.4.11, Арван хоёрын 12.1, 12.2.1 дэх заалтыг үндэслэн “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны татвар төлсний дараах цэвэр ашгаас ногдол ашиг болгон нэгж хувьцаанд 6960 (зургаан мянга есөн зуун жар) төгрөг хуваарилахаар тогтоосугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Ногдол ашгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувьцаа эзэмшигчдэд 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөнгөн хэлбэрээр тараасугай.
4. Тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлцэл байгуулах, төлбөр тооцоо хийх, тайлан мэдээг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж ажиллахыг гүйцэтгэх захирал (Ч.Гүнждагва)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ОТГОНБАЯР

# ТОГТООЛЫН ТӨСӨЛ

## Тогтоолын төсөл №1

### “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.14 дэх заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.9 дэх заалт, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн дэлгэрэнгүй тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.
2. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад зохих мэдээллийг хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд журмын дагуу хүргэж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

/Ш.ОТГОНБАЯР/

“Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон  
санхүүгийн тайланг хэлэлцсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.9 дэхь заалт, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

3. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн, баталсугай.
4. Хуралд танилцуулсан дүгнэлтийг цаашид бодлого шийдвэртээ тусгаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

/Ш.ОТГОНБАЯР/

“Тавантолгой” ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилан олгосон тайланг танилцуулах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.15 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.13 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.4.11 дэх заалт, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

5. “Тавантолгой” ХК-ийн 2023 оны жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахтай холбоотойгоор 2024 оны тайлант жилд гүйцэтгэсэн ногдол ашиг тараах үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.
6. Ногдол ашиг хуваарилан олгосон тухай мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн пагуу хувьцаа эзэмшигчид, олон нийтэд мэдээлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

/Ш.ОТГОНБАЯР/



“Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас  
ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн Удирдах  
Зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.13 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.4.11 дэх заалт, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

7. “Тавантолгой” ХК-ийн 2024 оны жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай 2025 оны 02 сарын 12-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн №11 тоот тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.
8. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан шийдвэрийн дагуу ногдол ашиг хуваарилах, хувьцаа эзэмшигчдэд бүрэн олгох ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

/Ш.ОТГОНБАЯР/

“Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.13 дахь заалт, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

9. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.
10. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлант жилийн хугацаанд гүйцэтгэсэн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

/Ш.ОТГОНБАЯР/

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон  
хараат бус гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.2, 77.4 дэх заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9, 6.14.7 дах заалт, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

11. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн, хараат бус гишүүдийг хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналыг кумулятив аргаар тоолж нэгтгэсэн дүнд үндэслэн дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай. Үүнд:

1. .... /ердийн гишүүн/
2. .... /ердийн гишүүн/
3. .... /ердийн гишүүн/
4. .... /ердийн гишүүн/
5. .... /ердийн гишүүн/
6. .... /ердийн гишүүн/
7. .... /хараат бус гишүүн/
8. .... /хараат бус гишүүн/
9. .... /хараат бус гишүүн/

12. Шинээр сонгогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг холбогдох хууль тогтоомжид заасан эрх, үүргийн хүрээнд идэвхи санаачлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

/Ш.ОТГОНБАЯР/

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны  
төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дах заалт, “Тавантолгой” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.14.12, 6.14.13 дахь заалт, Тооллогын комиссын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

13. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төсвийг тус тогтоолын №1 дугаартай хавсралтаар баталсугай.
14. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зардлын төсөвт хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Цалин урамшууллын хороонд даалгасугай.
15. Тогтоолын №1 дугаартай хавсралтаар баталсан Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөвт холбогдох зардлыг санхүүжүүлэхийг Гүйцэтгэх Удирдлагад зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

/Ш.ОТГОНБАЯР/

# САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

## “ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр .....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Регистерийн дугаар


Санал өгөх хувьцааны тоо .....

Бүртгэсэн /Үнэт цаасны компани / .....

Брокерийн овог ..... нэр .....

“Тавантолгой” ХК-ийн **Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал** 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00 цагт Өмнөговь аймгийн Цогтцэций сум, “Тавантолгой” ХК-ийн байранд хуралдана.

Саналын хуудас бөглөх заавар: **Дараах хэлэлцэх асуудлуудыг ЕРДИЙН АРГААР санал хураана.**

Ердийн аргаар саналаа өгөхөд асуудал бүрээр “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” аль нь болохыг тэмдэглэнэ.

№	ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Санал
1.	Тавантолгой ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай	Тогтоол №1				
2.	Тавантолгой ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай	Тогтоол №2				
3.	Тавантолгой ХК-ийн 2023 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилсан тухай тайланг танилцуулах	Тогтоол №3				
4.	Тавантолгой ХК-ийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг танилцуулах	Тогтоол №4				
5.	Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах	Тогтоол №5				
6.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг батлах тухай	Тогтоол №7				

Брокер: ..... /  
/ гарын үсэг, тэмдэг /

Хувьцаа эзэмшигч: ..... /  
/ гарын үсэг /

Саналын хуудсыг **хүчинтэйд** тооцов: ..... /  
Саналын хуудас **хүчингүйд** тооцсон бол шалтгаан:.....

2025 оны ... сар ... өдөр

**“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр .....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

Регистерийн дугаар


Эзэмшиж буй хувьцааны төрөл ..... тоо .....

Кумулятив хувьцааны тоо: .....

Бүртгэсэн /Үнэт цаасны компани / .....

Брокерийн овог ..... нэр .....

*“Тавантолгой” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00 цагт Өмнаговь аймгийн Цогтцэций сум, “Тавантолгой” ХК-ийн байранд хуралдана.*

3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох			
ТУЗ-ийн ердийн гишүүн:		Санал авах арга	Хурлаас гарах шийдвэрийн төсөл
1.	.....	Кумулятив	Тогтоол №6
2.	.....		
3.	.....		
4.	.....		
5.	.....		
6.	.....		
ТУЗ-ийн хараат бус гишүүн:			Нэр дэвшигчид өгөх саналын тоо
1.	.....		
2.	.....		
3.	.....		

Брокер ..... Гарын үсэг

/ тэмдэг /

Хувьцаа Эзэмшигч ..... Гарын үсэг

2025 ..... сар.....өдөр

*Саналын хуудсын хүчинтэйд тооцон тоолсон Тооллогын Комиссын дарга .....*

*Комиссын Гишүүн .....*

*Хүчингүйд тооцсон бол шалтгаан .....*

.....

.....

## САНАЛЫН ХУУДСЫГ БӨГЛӨХ САНАМЖ:

Саналын хуудсыг дараах зааврын дагуу бөглөнө

1. Саналыг ердийн аргаар тоолох асуудалд:

- Тухайн асуудалд зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэсэн аль нэгд нь ✓ эсвэл + тэмдгээр санал аа өгнө.
- Засварласан, балласан, эсвэл болон аль нэг саналыг бөглөөгүй бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.

2. Саналыг кумулятив аргаар тоолох асуудалд:

- ТУЗ-ийн гишүүдэд санал өгөхдөө кумулятив аргаар санал хураана
- Хувьцааны нэгж тутамд ТУЗ-ийн гишүүнийг сонгох 1 саналын эрх байна. Хувьцаа эзэмшигч саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

- Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамаарна.